

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ-Т ИРГЭД,
АЛБАН ХААГЧДААС ГАРГАСАН ӨРГӨДЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН

2022 оны 03 дугаар сарын 24

Багануур дүүрэг

2022 оны 01 дүгээр улиралд иргэд, албан хаагчдаас манай байгууллагад болон ажилтнуудад хандаж ирүүлсэн өргөдөл, санал хүсэлт байхгүй байна.

2021 оны 01 дүгээр улиралд иргэдээс ажилд орох, ажлаас чөлөөлөгдөх утгатай 2 өргөдөл ирж, хүсэлтийн дагуу "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ын даргын тушаал гаргаж, өдөр, өдөрт нь багтаан шийдвэрлэсэн байна. Ирсэн өргөдлүүдийг ERP системийн Өргөдөл, гомдол дэд хэсэгт бүртгэж, өргөдөл хяналтын картыг хөтлөн, өргөдлүүд болон өргөдөл хяналтын картаар хадгаламжийн нэгж үүсгэн тус тус архивласан.

Өргөдлийг хамгийн боломжит богино хугацаанд шийдвэрлэхийг зорьж байгаа бөгөөд ажлын 1 өдрийн дотор шийдвэрлэж байна.

Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй.


Бүтээлч санал санаачилгын шинжтэй хүсэлт илэрхийлж, мэдээлэл хүссэн иргэдтэй байгууллагын удирдлага биечлэн уулзаж, Паркийн зорилго чиглэл, үйл ажиллагааны тухай тодорхой мэдээлэл, зөвлөгөө, чиглэл өгч ажилладаг. Энэ уулзалтын бүртгэлийг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд улирал бүр албан бичгээр хүргүүлдэг. Иргэд, аж ахуйн нэгжээс гаргасан бүтээлч санал санаачилгын хүсэлтийг Паркийн үйл ажиллагаатай уялдуулан нааштайгаар шийдвэрлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангах зорилгыг хэрэгжүүлэн ажиллаж байгаагийн нэг илрэл нь Багануур дүүрэгт төмрийн үйлдвэр барих төсөл хэрэгжүүлж байгаа МЕСЕС ХХК-тай 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан гэрээ байгуулан ажиллаж байгаа явдал юм. Энэ ажлын хүрээнд Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хийгдэх Паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 6,76км урт, 110кВ-ын өндөр хүчдэлийн агаарын шугамын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр тендер зарлагдсан, 04 дүгээр сарын 04-ний өдөр нээлт хийж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулна гэсэн төлөвлөгөөтэй байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээ, тайланг байгууллагын цахим хуудасны ил тод байдал хэсэгт 2018 оноос эхлэн улирал бүр нээлттэй байршуулан ажиллаж байна.

Иргэдээс манай байгууллагын ажилтан, албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой гаргасан өргөдөл, гомдол байхгүй.

ХЯНАСАН:

ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН




Э.ЭНХЗАЯА

ТАЙЛАН ГАРГАСАН:

АРХИВ, БИЧИГ ХЭРЭГ, ГАДААД

ХАРИЛЦАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



М.МӨНХДУЛАМ